

Алба хэлтэс	Овог нэр	Албан тушаал	Огноо	Шалгалтын дун
Зуухан цех				

Техник ашиглалтын дүрмийн шалгалт

11. Зуух ба хийн хөндийн бүрхүүл гадаргуугийн нягтыг ямар хугацаанд үзэх ба агаар соролтыг нь хэмжих замаар хяналт тавьдаг байвал зохих бэ?
 - a. Сард 1 удаа
 - b. Улиралд 1 удаа
 - c. Жилд 1-ээс цөөнгүй удаа
12. Жишмэл түлш гэж юу вэ?
 - a. 8000 ккал/кг илчлэгтэй хийсвэр түлш
 - b. 7000 ккал/кг илчлэгтэй хийсвэр түлш
 - c. 7700 ккал/кг илчлэгтэй хийсвэр түлш
13. Богино холбоотой ротор бүхий хөдөлгүүрийг халсан байдлаас
 - a. 1 удаа давтан залгахыг зөвшөөрнө.
 - b. Хөндийрүүлэгийн эсэргүүцлийг хэмжиж, шалгалт хийсний дараа дахин залгахыг зөвшөөрнө.
 - c. 2 удаа давтан залгахыг зөвшөөрнө.
14. Эргэх хэсэг нь түргэн элэгддэг нүүрс бутлагч, утаа сорогч, салхилуур зэрэг механизмуудын эргэлт 3000 эрг/мин бол доргионы хэвийн хэмжээ хэд байх ёстой бэ?
 - a. Холхивчийн зөвшөөрөгдөх доргио 30 мкм ихгүй
 - b. Холхивчийн зөвшөөрөгдөх доргио 50 мкм ихгүй
 - c. Холхивчийн зөвшөөрөгдөх доргио 100 мкм ихгүй
15. Зуухыг угсралт, их засварын дараа буюу бэлтгэлээс галлахад үргэлжийн үлээлгийн хэмжээг хэдэн хувь хүртэл нэмэгдүүлж болох бэ?
 - a. 0.5-1%
 - b. 0.5-3%
 - c. 2-5%
16. Даралтад савны шугам хоолойг ашиглах дүрэм зөрчиж осол гаргахад ослыг хэн судлах вэ?
 - a. Улсын техник хяналтын байгууллага
 - b. Байгууллагын техник хяналтын хэсэг
 - c. Ерөнхий инженерээр ахлуулсан комисс
17. Даралтад саванд усан сорил хийх даралтын хэмжээ хэд байх бэ?
 - a. $P_{\text{сор}} = 1.5P_{\text{ажил}}$
 - b. $P_{\text{сор}} = 1.25P_{\text{ажил}}$
 - c. $P_{\text{сор}} = 1.1P_{\text{ажил}}$
18. ДЦС-н үндсэн тоноглолыг үндсэн, тоноглолыг ямар хугацаанд ажиллуулсаны дараа туршилтыг дууссан гэж үзэх вэ?
 - a. 24 цаг
 - b. 48 цаг
 - c. 72 цаг
 - d. 7 хоног
19. Дулаанжуулалтын тоног төхөөрөмжийн туршилтыг ямар үед хийх вэ?
 - a. Шэнээр ашиглалтанд орж байгаа дулаанжуулалтын тоног төхөөрөмжид болон ашиглалтын явцад 2 жилд
 - b. Шэнээр ашиглалтанд орж байгаа дулаанжуулалтын тоног төхөөрөмжид болон ашиглалтын явцад 3-4 жилд
 - c. Шэнээр ашиглалтанд орж байгаа дулаанжуулалтын тоног төхөөрөмжид болон ашиглалтын явцад жилд 1 удаа дулаанжуулалтын улирал эхлэхээс өмнө
20. Эрчим хүчний үйлдвэрийн барилга байгууламжид техникийн үзлэгийг ямар хугацаанд хийх вэ?
 - a. Жилд 1 удаа /хавар/
 - b. Жилд хоёр удаа / хавар намар/
 - c. Жилд 1 удаа /намар
21. ДЦС станцын үндсэн зорилго юу вэ?
 - a. Дулааны эрчим хүч үйлдвэрлэх
 - b. Дулаан цахилгааны эрчим хүч хувиарлах
 - c. Дулаан цахилгааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах
 - d. Дулаан цахилгааны эрчим хүч үйлдвэрлэх
22. Станцын уурын зуух нь ямар байгууллагын хяналтанд байдаг вэ?
 - a. Мэргэжлийн хяналтын газар
 - b. Станцын хяналтын хэлтэс

Алба хэлтэс	Овог нэр	Албан тушаал	Огноо	Шалгалтын дүн
Зуухан цех				

Техник ашиглалтын дүрмийн шалгалт

- c. ДҮТ-ийн диспетчерийн алба
d. Эрчим хүчний яамны техник хяналтын хэлтэст
23. 100кг/см²/9.8 МПа /-аас доош даралттай уурын ба ус халаах зуухнуудыг ашиглалтанд оруулахын өмнө ямар угаалаг хийх бэ?
a. Шүлтээр угаана.
b. Химийн цэвэр усаар угаана
c. Аммиа химийн нэгдлээр угаана
24. Зуухыг галлахын өмнө болон зогсоосны дараа зуухны галын хотол, утааны ба богино эргэлтийн шугам хоолойг яаж үлээлгэж салхилуулсан байх ёстой бэ?
a. Агаарын хэвийн зарцуулалтын 30 %-тай тэнцэх хэмжээний агаараар 15 минутаас доошгүй хугацаанд
b. Агаарын хэвийн зарцуулалтын 25 %-тай тэнцэх хэмжээний агаараар 10 минутаас доошгүй хугацаанд
c. Агаарын хэвийн зарцуулалтын 20 %-тай тэнцэх хэмжээний агаараар 25 минутаас доошгүй хугацаанд
25. Зуухыг зогсоох үеийн барабаны хөргөлтийн хурд хэд байх ёстой бэ?
a. 10 минутын хугацаанд 20°C-ээр нэмэгдэхээр
b. 10 минутын хугацаанд 30°C-ээр нэмэгдэхээр
c. 20 минутын хугацаанд 30°C-ээр нэмэгдэхээр
26. Бүрэн хөрөөгүй хоосорсон барабаны дээд талын металлын температур хэд байх үед усаар шахахыг зөвшөөрөх бэ?
a. Дээд талын металлын температур 160°C-ээс ихгүй
b. Дээд талын металлын температур 160°C-ээс дээш үед
c. Тэжээлийн усны температур 95°C-ээс дээш үед
d. Тэжээлийн усаар шууд тэжээнэ
27. Зуухны барабан, коллекторууд, экрануудын дулаан тэлэлтийг реперээр шалгадаг байвал зохих бэ?
a. Дунд засвараас галлахад
b. Их засвараас галлахад
c. Жилд 1-ээс доошгүй удаа
d. Дээрхи бүгд зөв
28. Зуухны галын хотол дахь хүйтэн агаарын соролт ямар хугацаанд хийдэг байх бэ?
a. Жилд 1-ээс цөөнгүй удаа туршилтаар шалгаж үзнэ
b. Их ба дунд засварын өмнө туршилтаар шалгаж үзнэ
c. Их ба дунд засварын хойно туршилтаар шалгаж үзнэ
d. Дээрхи бүгд зөв
29. Зуухыг аль тохиолдолд шууд зогсоож, уурын шугамаас таслах бэ?
A. Шууд урсгалтай уурын ба ус халаах зуухны тэжээлийн усны бүх зарцуулалтын хэмжүүрүүд ажилгүй болох буюу тэжээл нь 30 секундээс их хугацаагаар тасарвал.
B. Ажиллагсад болон тоног төхөөрөмж, түүний алсын удирдлага ба зуухны хамгаалалтын байгууламжид аюул учруулахаар гал түймэр гарвал
C. Зарим чухал хамгаалалт, алсын ба автомат удирдлагын хэсгүүд болон хэмжих хянах багажууд гэмтэлтэй болбол
D. Тэжээх байгууламж (насос)-ууд бүгд зогсвол
a. A,B,C,D b. A,B,C c. A,B,D d. A,C,D
30. Хөдөлгүүр хэт ачаалалгдахад үл хамаарах хүчин зүйл аль нь ба
a. Сальник хэт чангалсан байх
b. Ажлын дугуй гэмтэх
c. Зарцуулалт их байх
31. Бэлтгэлд удаан хугацаагаар зогсож байгаа хөдөлгүүрийг механизмын нь хамт хэдий хугацаанд явуулж шалгадаг байх ёстой вэ?
a. Ерөнхий инженерээр батлагдсан графикайн дагуу
b. Сар бүр явуулж шалгадаг байх ёстой.
c. Улиралд 1 доошгүй удаа явуулж шалгадаг байх ёстой.

Алба хэлтэс	Овог нэр	Албан тушаал	Огноо	Шалгалтын дун
Зуухан цех				

Техник ашиглалтын дүрмийн шалгалт

32. Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн удирдах хэрэглэлд шууд нөлөөлөх, тэдгээрийн үйлдвэрлэлийн хэсгүүдэд үйлчилгээ явуулж байгаа хүмүүсийг ?
 - a. Засварын хүмүүс
 - b. Шуурхай ажиллагааны ээлжийн хүмүүс
 - c. Удирдах инженер техникийн ажилтнууд
33. Зуухны тогтворжсон горимын үед үргэлжийн үлээлгийн усны алдагдлыг химийн цэвэрлэсэн усаар нөхөж буй бол зуухны уурын чадлын хэдэн хувь байх бэ?
 - a. 0.5-1%
 - b. 0.5-3%
 - c. 2-5%
34. Даралтад сав шугам хоолойн 1-р ангиллын 4-р бүлэгт ямар параметртэй шугам хоолой орох бэ?
 - a. Ажлын биеийн температур 560°C -аас дээш даралт хязгааргүй
 - b. Ажлын биеийн температур $350 - 450^{\circ}\text{C}$ даралт 80 кгс/см^2 хүртэл
 - c. Ажлын биеийн температур 450°C хүртэл даралт 80 кгс/см^2 -аас илүү
35. Даралтад савны хананы зузаан 50мм бол туршилтанд ямар хугацаанд барих бэ?
 - a. 10 минут
 - b. 20 минут
 - c. 30 минут
36. Ажилагсадаас мэдлэгийн шалгалт авч мэргэжлийн зэрэг олгох ажлыг хэн хийх вэ?
 - a. Ерөнхий инженерээр ахлуулсан комисс
 - b. Сургалтын инженер
 - c. Хүний нөөц, албадын дарга нарын комисс
 - d. Техник ашиглалтын байцаагч инженер, Аюулгүй ажиллагааны байцаагч инженер нарын бүрэлдэхүүнтэй комисс
37. Зуухыг зогсоох үйлчилгээтэй хориг ба хамгаалалтын хэрэгслэлүүд ажиллагаагүй байвал зуухыг явуулахыг зөвшөөрөх үү.
 - a. Зөвшөөрнө
 - b. Хориглоно
 - c. Цехийн даргын шийдвэрээр явуулахыг зөвшөөрнө
 - d. Ерөнхий инженерийн шийдвэрээр явуулахыг зөвшөөрнө
38. Зуухыг янз бүрийн дулааны байдлаас эхлэн галлахдаа яаж галлах бэ?
 - a. Батлагдсан галлагааны горимын карт, графикийн дагуу гүйцэтгэнэ.
 - b. Зуухны халуун, хүйтэн байдал, диспетчерийн график хугацаанаас хамаарч ээлжийн даргын өгсөн шийдвэрийн дагуу гүйцэтгэнэ
 - c. Зуухны халуун, хүйтэн байдал, диспетчерийн график хугацаанаас хамаарч ээлжийн инженерийн өгсөн шийдвэрийн дагуу гүйцэтгэнэ
39. Зуухыг галлагааны үеийн барабаны дээд, доод талуудын температурын зөрүү хэдээс хэтрэхгүй байх ёстой бэ?
 - a. 30°C -аас хэтрэхгүй байх
 - b. 80°C -аас хэтрэхгүй байх
 - c. 60°C -аас хэтрэхгүй байх
40. Зуухыг галлахын өмнө болон зогсоосны дараа агаарын хэвийн зарцуулалтын 25%-тай тэнцэх хэмжээний агаараар зуухны галын хотол, утаа ба богино эргэлтийн эргэлтийн шугам хоолойг хэдий хугацаанд үлээлгэж салхилжуулах бэ?
 - a. 10 минутаас доошгүй
 - b. 30 минутаас илүүгүй
 - c. 30 минутаас доошгүй
41. Зуухны ханын өрлөг байнга хэвийн байх ёстой. Орчны температур нь 25°C байхад өрлөгийн гадаргуу дахь температур нь хэдээс ихгүй байх ёстой.
 - a. 35°C -ээс
 - b. 40°C -ээс
 - c. 45°C -ээс
42. Зогсоосон зуухыг түргэн хөргөх зорилгоор ус хийж, юүлэхийг зөвшөөрөх үү
 - a. Зөвшөөрнө
 - b. Шийдвэрээр зөвшөөрнө
 - c. Хориглоно
43. Зуухыг дараах тохиолдолд цахилгаан станцын ерөнхий инженерийн шийдвэрээр зогсооно.
 - A. Зуухны халах гадаргуугийн хоолой, ус оруулах буулгах хоолой болон уурын шугам, коллектор, тэжээлийн шугамд үлээлт шүүрэлт гарах, мөн арматур, фланцан ба хэлбэлтэн холбоосуудаар уур ус алдагдах,

Алба хэлтэс	Овог нэр	Албан тушаал	Огноо	Шалгалтын дүн
Зуухан цех				

Техник ашиглалтын дүрмийн шалгалт

- В. Зуухны халах гадаргуугийн металлын температур хэт ихсэж, тэр нь зуухны ажиллагааны горимыг өөрчилсөөр байхад буурахгүй байвал,
 С. Зуухны тогооны усны түвшинг алсаас заагч хэмжүүрүүд бүгд ажиллахгүй болвол
 D. Хамгаалах кпаланууд буюу тэдгээрийг орлох хамгаалах байгууламжуудын 50% /ба дээш/ нь ажиллахгүй болбол
- a. A,B,C,D b. A,B,C c. A,B,D d. A,C,D
44. Буцаахгүй клапан ямар үүрэг гүйцэтгэх вэ?
 a. Насосыг хий сорохоос хамгаална
 b. Насосыг зогсоох буюу бэлтгэлд зогсооход насосанд буцаж урсгал орохоос хамгаалсан байна
 c. Насосыг бэлтгэлд зогсооход насосонд кавитаци үүсэхээс хамгаална
45. Хэрэв зааварт доргионы хэмжээг заагаагүй бол, механизмтай нь холбосон эргэлт 3000 эрг/мин хөдөлгүүрийн холхивчийн доргионы зөвшөөрөгдөх хэмжээ
 a. Холхивчийн зөвшөөрөгдөх доргио 30 мкм ихгүй
 b. Холхивчийн зөвшөөрөгдөх доргио 60 мкм ихгүй
 c. Холхивчийн зөвшөөрөгдөх доргио 80 мкм ихгүй
46. Шуурхай ажиллагааны дээд шатны хүмүүсээс өгсөн даалгаврыг үндэслэлгүйгээр саатуулсан буюу биелүүлээгүйн хариуцлагыг хэн хүлээх бэ?
 a. Даалгавар биелүүлээгүй шуурхай ажиллагааны хүмүүс
 b. Саатуулсан буюу биелүүлэхгүй байхыг зөвшөөрсөн удирдах ажилтан
 c. Дээрхи 2 зөв
47. Зуухны уурын натрийн нэгдлүүд ба цахиурын хүчлийн агуулга болон хувийн цахилгаан дамжуулалт нормоос 2 дахин ихэссэн бол
 a. Шалтгааныг 72 цагийн дотор илрүүлж устгах ёстой.
 b. Шалтгааныг 36 цагийн дотор илрүүлэн устгах ёстой.
 c. Шалтгааныг 24 цагийн дотор илрүүлэн устгах ёстой.
48. Даралтад савыг ажиллуулах, аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангах зорилгоор ямар хэрэгслээр тоноглогдсон байдаг бэ?
 a. Хаах буюу тохируулах арматур, температур хэмжих хэрэгсэл, даралт хэмжих хэрэгсэл, хамгаалах төхөөрөмж, түвшин заагч
 b. Хаах арматур, температур хэмжих хэрэгсэл, даралт хэмжих хэрэгсэл, хамгаалах төхөөрөмж
 c. Температур хэмжих хэрэгсэл, даралт хэмжих хэрэгсэл, түвшин заагч
49. Даралтад саванд хамгаалах хавхлагыг ямар даралтаар тохируулж тавих бэ?
 a. $P_{xx} = 1.5P_{ажил}$
 b. $P_{xx} = P_{сорил}$
 c. $P_{xx} = 1.1P_{ажил}$
50. Эрчим хүчний салбарын нийт ажилагсад ямар үүрэг хүлээж ажиллах вэ?
 А. Тоног төхөөрөмж, барилга байгууламжийг ашиглахад байнга бэлэн байлгах
 В. Эрчих хүчний үйлдвэрлэлийг $\frac{1}{3}$ -н хамгийн өндөр үр ашигтай найдвартай ажиллагаа
 С. Хөдөлмөрийн аюулгүй байдал ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлэх
 D. Цахилгаан дулааны эрчим хүчийг тасралтгүйгээр хэрэглээтэй нь тэнцвэржүүлэн үйлдвэрлэх
 a. A,B,C,D b. B,C c. A,B,C d. A,C,D
51. Гал унтраах мэргэжлийн анги ирэх хүртэл гал түймрийг унтраах ажлыг хэн удирдах вэ?
 a. ДИС
 b. Ээлжийн дарга
 c. Цехийн дарга
 d. Ашиглалтын ИТА
52. Тоног төхөөрөмжийн техник эдийн засгийн үзүүлэлтийн норматив тодорхойломж ачааллын өсөлт бууралт хэдэн хувиар илүү гарсан нөхцөлд түүний мэргэжлийн байгууллагын туршилтаар шинэчлэн тогтоолгох вэ?
 a. 50%
 b. 40%
 c. 30%
 d. 20%

Алба хэлтэс	Овог нэр	Албан тушаал	Огноо	Шалгалтын дүн
Зуухан цех				

Техник ашиглалтын дүрмийн шалгалт

53. Техникийн магадлалын дүнг яах ёстой вэ?
 - a. Техникийн зөвлөлд танилцуулна
 - b. Протоколдоно
 - c. Техникийн паспортанд бичнэ
 - d. Мэргэжлийн хяналтын байгуулгад танилцуулна
54. Техникийн магадлалын зорилгод хамаарахгүй нь аль вэ?
 - a. Техникийн төлөв байдалд үнэлэлт өгөх
 - b. Цаашдын нөхцөл хугацааг тогтоох
 - c. Техникийн нөхцөлийг хангахад зайлгүй шаардлагатай арга хэмжээнүүдийг тогтоох
 - d. ТЭЗҮ-ийг тооцно
55. Зуухыг галлаж явуулах ажлыг жирийн үед хэн удирдан зохион байгуулах бэ?
 - a. Ээлжийн дарга буюу ахлах машинч
 - b. Цехийн дарга буюу түүний орлогч
 - c. Ээлжийн инженер
 - d. Дээхи бүгд зөв
56. Зуухыг зогсоох үеийн барабаны дээд, доод талуудын температурын зөрүү хэдээс хэтрэхгүй байх ёстой бэ?
 - a. 30°C-аас хэтрэхгүй байх
 - b. 60°C-аас хэтрэхгүй байх
 - c. 80°C-аас хэтрэхгүй байх
57. 40 кгс/см²-аас дээш даралттай зуухыг галлах үед тогооны түвшинь хэмжүүрийг үлээлгэж цэвэрлэж байх ёстой бэ?
 - a. 3 кгс/см² ба 15-30 кгс/см² илүүдэл даралттай үед
 - b. 1 кгс/см² илүүдэл даралттай үед
 - c. Уурын шугамд залгахаас өмнө
 - d. Дээрхи бүгд зөв
58. Үнс барих цахилгаан шүүлтүүрт агаар соролт ямар байх ёстой бэ?
 - a. 5%-иас ихгүй
 - b. 10%-иас ихгүй
 - c. 15%-иас ихгүй
59. Богино холбоотой ротор бүхий хөдөлгүүрийг хүйтэн байдлаас
 - a. 1 удаа давтан залгахыг зөвшөөрнө.
 - b. 2 удаа давтан залгахыг зөвшөөрнө.
 - c. Хөндийрүүлэгийн эсэргүүцлийг хэмжиж, шалгалт хийсний дараа дахин залгахыг зөвшөөрнө.
60. Хөдөлгүүр нь үндсэн хамгаалалтаар тасарвал
 - a. 1 удаа давтан залгахыг зөвшөөрнө.
 - b. 2 удаа давтан залгахыг зөвшөөрнө.
 - c. Хөндийрүүлэгийн эсэргүүцлийг хэмжиж, шалгалт хийсний дараа дахин залгахыг зөвшөөрнө.
61. Эргэх хэсэг нь түргэн элэгддэг нүүрс бутлагч, утаа сорогч, салхилуур зэрэг механизмуудын эргэлт 1500 эрг/мин бол доргионы хэвийн хэмжээ хэд байх ёстой бэ?
 - a. Холхивчийн зөвшөөрөгдөх доргио 30 мкм ихгүй
 - b. Холхивчийн зөвшөөрөгдөх доргио 50 мкм ихгүй
 - c. Холхивчийн зөвшөөрөгдөх доргио 100 мкм ихгүй
62. Уур, усны сорьц хөргүүр сорьцыг хэдэг градус хөргөдөг байх ёстой бэ?
 - a. 20°C хүртэл хөргөдөг байх
 - b. 20-40°C хүртэл хөргөдөг байх
 - c. 30-50°C хүртэл хөргөдөг байх
63. Даралтад савны манометр хянах байрнаас хэдэн метр өндөрт байрлуулахыг хориглох бэ?
 - a. 1.5 метр
 - b. 2 метр
 - c. 3 метр